


ИНФОГРАФИК: ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Өмнөх сартай харьцуулсан үзүүлэлт





ЭКСПОРТЫН ГОЛ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ХЭМЖЭЭ БОЛОН ДУНДАЖ ҮНЭ

Экспортын гол бүтээгдэхүүний хэмжээ болон дундаж үнийг графикаар оны эцсийн байдлаар харуулав.



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ИНФОГРАФИК- САР ТУТМЫН БУСАД ҮЗҮҮЛЭЛТҮҮД



ЭДИЙН ЗАСАГ ЯМАР БАЙХ ВЭ?- ТААМАГ (ОУЭЗБ)

ДНБ-ий өсөлт: 2021 онд: 5.1%,
Инфляци: 2021 онд: 8.2%,
Урсгал тэнцэл: 2021 онд: -8.3%-тай байхыг Азийн хөгжлийн банк (АЗХБ) 2020 оны тайланд прогноз хийсэн байна.

Эх сурвалж: <https://bit.ly/30pG2Et>


ДНБ-ий өсөлт: 2021 онд: 6%
Инфляци: 2021 онд: 5.5%,
ДНБ-д эзлэх урсгал тэнцэл: 2021 онд: -13.5%- Олон улсын валютын сан (ОУВС)-аас гаргадаг (Дэлхийн эдийн засгийн төлөв байдлын судалгаа, 2020 он) тайланд дурдсан байна.

Эх сурвалж: <https://bit.ly/3qx1ORq>

ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД: УЛСЫН ТӨСӨВ, ВАЛЮТЫН ХАНШ, ИНФЛЯЦИ, ГАДААД ХУДАЛДАА


Төсвийн тэнцэл 11-р сарын байдлаар (1887) тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа.

Улсын нэгдсэн төсвийн орлого өмнөх жилийн мөн үеэс 62 хувиар өссөн бол, зарлага 31.7 хувиар буурч төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 1887 тэрбум төгрөгийн алдагдалтай гарав. Төсвийн алдагдал өнгөрсөн оны мөн үеэс 49.1 тэрбум төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.




Ам.долларын ханш өмнөх сараас 0.02 төгрөгөөр буурчээ.

Арваннэгдүгээр сард Монголбанкны төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн дундаж ханш өнгөрсөн оны мөн үеэс -1.05 төгрөгөөр буурч, өмнөх сартай харьцуулахад 0.02 төгрөгөөр буурч 2848.95 төгрөг болов. 11-р сард гадаад валютын нөөц 4.1 тэрбум төгрөг буюу өнгөрсөн сараас 0.86 оны эхнээс 8.14 хувиар буурч, өнгөрсөн оны мөн үеэс 7.63 хувиар өссөн үзүүлэлттэй байна.




Инфляцийн түвшин 10.5%

Хэрэглээний үнийн индекс улсын хэмжээнд 2021 оны 11-р сарын байдлаар өмнөх сараас 1.3 хувиар нэмэгдэж, өмнөх оны мөн үеэс 10.5 хувиар, оны эхнээс 11.1 хувь өсөв. 11 дүгээр сард өмнөх сараас 1.3 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 2.0 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 1.6 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ дүнгээрээ 0.9 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ дүнгээрээ 1.4 хувь тээврийн бүлгийн үнэ дүнгээрээ 2.4 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.




Гадаад худалдааны тэнцэл 2642 сая.ам долларын ашигтай гарав.

2021 оны арваннэгдүгээр сард нийт барааны эргэлт 15,018 тэрбум төгрөг буюу өмнөх оны мөн үеэс 27.9 хувиар нэмэгдсэн бол экспорт өмнөх сараас 28.8 хувь нэмэгдэж, импорт өмнөх оны мөн үеэс 26.6 хувиар нэмэгдэж гадаад худалдааны тэнцэл 2642 сая ам.долларын ашигтай гарав.



11-Р САРЫН ОНЦЛОХ: ЗЭЭЛ

Эх сурвалж: www.mongolbank.mn

ААН, байгууллага, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл 2021 оны 11-р сард өмнөх сараас 1 хувиар, өнгөрсөн оны мөн үеэс 19.2 хувиар тус тус өсч 20.2 их наяд төгрөг болов. Чанаргүй зээлийн хэмжээ 2016 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 2 хувиар өсч, өнгөрсөн оны мөн үеэс 0.2 хувиар өссөн байна. Нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн өрийн үлдэгдэл 9.9% байна. Банкны системийн хэмжээгээр чанаргүй зээл 2021 оны 11 дүгээр сарын эцэст 2.0 их наяд төгрөг болж, өмнөх сараас 39.1 (2.0%) тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 3.1 (0.2%) тэрбум төгрөгөөр өссөн байна. Чанаргүй зээл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 10.0 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс 1.9 нэгж хувиар буурчээ.

САРЫН ОНЦЛОХ

2021 ОНЫ ЭХНИЙ 9 САРД 787.2 ТЭРБУМ ТӨГРӨГИЙН ИПОТЕКИЙН ЗЭЭЛ ОЛГОЖЭЭ

- Монголбанк болон банкны эх үүсвэрээр энэ оны эхний есөн сард 10.5 мянган өрхөд 787.2 тэрбум төгрөгийн ипотекийн зээл олгожээ. Энэ нь 2021 онд сард дунджаар 87.9 тэрбум төгрөгийн зээлийг олгосон байна. Монголбанкнаас энэ оны 10 болон 11 дүгээр сард тус бүр 40 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг арилжааны банкуудад хуваарилсан бол банкууд өөрийн эх үүсвэрээр 26.7 тэрбум төгрөг гаргана. Монголбанкнаас тус хөтөлбөрийг 2023 онд багтаан Засгийн газарт бүрэн шилжүүлэх бэлтгэл ажлыг хангаж байгаа бөгөөд энэ хугацаанд хөтөлбөрийн тасралтгүй байдлыг хангаж ажиллахаа мэдэгдсэн байна.

ОРОН СУУЦНЫ ҮНЭ ӨМНӨХ УЛИРЛЫНХААС 1.4 ХУВИАР НЭМЭГДЖЭЭ

- Улаанбаатар хотын төвийн 6 дүүрэгт орон сууцны үнэ энэ оны гуравдугаар улиралд 2010 оны эцсийнхээс 81.7, өмнөх оны мөн үеийнхээс 1.3, өмнөх улирлынхаас 1.4 хувиар нэмэгджээ. Тодруулбал, орон сууцны үнэ гуравдугаар улиралд өмнөх оны мөн үеийнхээс Баянгол дүүрэгт 2.5, Хан-Уул дүүрэгт 2.2, Чингэлтэй, Сүхбаатар дүүрэгт 1.8, Баянзүрх дүүрэгт 0.7 хувиар нэмэгдэв. Харин Сонгинохайрхан дүүрэгт 1.1 хувиар багассаныг Үндэсний статистикийн хороо мэдээлэв. Орон сууцны үнийн индекс өмнөх улирлынхаас 1.4 хувиар нэмэгдэхэд 2001 оноос хойш ашиглалтад орсон шинэ орон сууцны үнэ Хан-Уул дүүрэгт 3.8, Баянгол дүүрэгт 2.9 хувиар нэмэгдсэн нь нөлөөлжээ.

Эх сурвалж:

- Статистикийн бюллетень, 11-р сар 2021 он, Үндэсний статистикийн хороо
- Статистикийн бюллетень, 11-р сар 2021 он, Монголбанк
- www.1212.mn, www.mongolbank.mn, www.montsame.mn